

“ИНТЕРНЭТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ХҮСЭЛТ - БАЙГУУЛЛАГА”

Эрхэм харилцагч та дараах мэдээллийг зааврын дагуу үнэн зөв, гаргацтай бөглөнө үү.

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ:

(Голомт банкны үндсэн системийн бүртгэл дэх мэдээлэлтэй ижил байх ёстой. Хэрэв уг мэдээлэл өөрчлөгдсөн бол банкны бүртгэлийн системд мэдээлэл өөрчлүүлэх хүсэлт бөглөнө.)

Байгууллагын нэр: _____

Байгууллагын хаяг: _____

Утас: _____ Факс: _____ И-мэйл: _____

ИНТЕРНЭТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХИЙН ТҮВШНИЙ МЭДЭЭЛЭЛ:

Байгууллагын интернэт банкны ерөнхий эрхийн түвшин:

- Харах эрх /Гүйлгээ хийх эрхгүй/
- Энгийн эрх /20сая – 100 сая ₮ хүртэл лимиттэй/
- Тусгай эрх /100 саяас дээш/
 - Өдрийн гүйлгээний лимит: _____ /тоогоор/ _____ /үсгээр/
 - Нэг удаагийн гүйлгээний лимит: Эрх авахгүй Эрх авна /лимит/ _____
 - Цалингийн багц гүйлгээний лимит: Эрх авахгүй Эрх авна /1 сар/ _____
 - Эрхийн тохиргооны түвшин: Дан эрх Давхар хяналттай эрх

Жич: Өөрийн данс хооронд гүйлгээ нь өдрийн гүйлгээний лимитэд тооцогдохгүй.

БАЙГУУЛЛАГЫН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ:

Харилцагчийн бүх данс интернэт банкны үйлчилгээнд автоматаар холбогдох бөгөөд оруулахгүй данс байгаа бол тодорхойлно уу.

Интернэт банкинд холбохгүй дансны дугаар: _____

БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЕТ БАНК ХАРИЛЦАГЧИЙН ЭРХИЙН ТҮВШИН:

Банк таны хүсэлтэнд тодорхойлсон доорх ажилтнуудад интернэт банкны үйлчилгээ ашиглаж дансыг удирдах бүрэн эрх олгож нэвтрэх нэр, нууц уг, нууцлалын төхөөрөмжийг тус бүрд нь олгох болно. Иймээс та интернэт банкны үйлчилгээний эрхийн түвшингүүд, тэдгээрийн ялгааг сайтар уншиж танилцаж сонголтлоо зөв хийнэ үү.

Харах болон гүйлгээ хийх эрхтэй харилцагчид:

	Харилцагч №1	Харилцагч №2	Харилцагч №3
Овог, нэр:			
Регистрийн дугаар:			
Албан тушаал:			
И-мэйл хаяг: <i>Уг и-мэйл хаяг руу интернэт банкаар хийгдсэн гүйлгээний мэдээлэл илгээгдэх болохыг анхаарна уу.</i>			
Утасны дугаар: <i>Уг утас руу интернэт банкаар хийгдсэн гүйлгээний мэдээлэл илгээгдэх болохыг анхаарна уу.</i>			
Эрхийн түвшин <i>Ард буй мэдээллийг уншиж эрхийн түвшний сонголтлоо зөв хийнэ үү.</i>	<input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхгүй ХАРАХ эрх <input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхтэй лимит: _____	<input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхгүй ХАРАХ эрх <input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхтэй лимит: _____	<input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхгүй ХАРАХ эрх <input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхтэй лимит: _____

*Харилцагчийн тоо 3-аас их бол албан хүсэлт бүхий бичгээр тодорхой зааж өгнө үү.

Хянах болон батлах эрхтэй харилцагчид:

	Харилцагч №1	Харилцагч №2	Харилцагч №3
Овог, нэр:			
Регистрийн дугаар:			
Албан тушаал:			
И-мэйл хаяг: <i>Уг и-мэйл хаяг руу интернэт банкаар хийгдсэн гүйлгээний мэдээлэл илгээгдэх болохыг анхаарна уу.</i>			
Утасны дугаар: <i>Уг утас руу интернэт банкаар хийгдсэн гүйлгээний мэдээлэл илгээгдэх болохыг анхаарна уу.</i>			
Эрхийн түвшин <i>Ард буй мэдээллийг уншиж эрхийн түвшний сонголтоо зөв хийнэ үү.</i>	<input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхгүй ХЯНАХ эрх <input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхтэй ХЯНАХ эрх лимит: _____ <input type="checkbox"/> Хянагдсан гүйлгээг БАТЛАХ эрх	<input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхгүй ХЯНАХ эрх <input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхтэй ХЯНАХ эрх лимит: _____ <input type="checkbox"/> Хянагдсан гүйлгээг БАТЛАХ эрх	<input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхгүй ХЯНАХ эрх <input type="checkbox"/> Гүйлгээ хийх эрхтэй ХЯНАХ эрх лимит: _____ <input type="checkbox"/> Хянагдсан гүйлгээг БАТЛАХ эрх

ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

Би/Бид интернэт банкны үйлчилгээ авах хүсэлтийг бөглөх зааварчилгааг уншиж танилцсан бөгөөд ойлгож хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлж байна. Би/Бид дээр тодорхойлсон ажилтнуудад байгууллагын дансанд интернэт банкны үйлчилгээ авах, интернэтээр данс удирдах боломжийг олгох хүсэлтэй байгаагаа илэрхийлж байна. Би/Бид интернэт банкны үйлчилгээний санамж, аюулгүй байдлын зааварчилгаатай бүрэн танилцсан бөгөөд гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна.

Баталгаат гарын үсэг: /1-р гарын үсэг/ _____

Байгууллагын тамга:



Баталгаат гарын үсэг: /2-р гарын үсэг/ _____

БАНКНЫ ТЭМДЭГЛЭЛ:

Хүсэлт хүлээн авсан огноо: _____

Үйлчилгээний эрх нээсэн огноо: _____

Хүлээн авсан салбарын нэр: _____

Хүсэлт хүлээн авсан ажилтан: _____ /

/

БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЭТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ХҮСЭГЧИД ЗОРИУЛСАН САНАМЖ

Интернэт банкны үйлчилгээг хэрэглэх ажилтныг сонгоход анхаарах зүйл:

- Та энэхүү хүсэлтэд тодорхойлж буй ажилтнуудад байгууллагынхаа дансанд интернэт банкны үйлчилгээ авч, дансыг удирдах бүрэн эрх олгож байгаа гэдгийг анхаарч доор тайлбарласан Харах, Энгийн болон тусгай эрхийн боломжууд, ялгаатай талыг уншиж танилцан сонголтой зөв хийх хэрэгтэй;
- Та интернэт банкны үйлчилгээг хэрэглэх ажилтнаа сонгохдоо байгууллагын данснаас зарлагын гүйлгээ гаргах эрх бүхий албан тушаалтнуудыг сонгохыг зөвлөж байна;
- Таны тодорхойлсон ажилтнуудын интернэт банкаар хийсэн гүйлгээ, үйлдлийг банк хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрнө гэдгийг анхаарна уу. Иймээс танай ажилтны санаатай болон санамсаргүй үйлдлээс үүдэн гарах хариуцлагыг банк хариуцахгүй болно.

Интернэт банкны үйлчилгээ авахтай холбоотой анхаарах зүйл:

- Банк харилцагчийг интернэт банкны үйлчилгээнд бүртгэх үед харилцагчийн нууц үг болон гүйлгээний нууц үг нь хүсэлтэнд бүртгэлтэй и-мэйл хаяг уруу системээс автоматаар илгээгдэх болно;
- Интернэт банкны үйлчилгээнд анх нэвтрэх үед системээс нууц үгийг солихыг сануулах ба зааврын дагуу нууц үгээ солих хэрэгтэй;
- Интернэт банкаар хийж буй гүйлгээг баталгаажуулах хэрэгсэл нь харилцагчид олгосон нууцлалын төхөөрөмж учир уг төхөөрөмжийг бусдад алдахаас сэргийлэх хэрэгтэй;
- Харилцагч нь интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгээ бусдад дамжуулахгүй байх, бусдад алдахаас сэргийлэх хэрэгтэй ба аливаа нэг газар бичиж тэмдэглэхгүй байх, хэт амархан тааж болохоор нууц үг сонгохгүй байх зэргийг анхаарна уу;
- Харилцагч нь интернэт банкны үйлчилгээ авч буй компьютер, сүлжээ, гар утас зэрэг төхөөрөмжүүдийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж ажиллах ёстой;
- Харилцагч нь интернэт банкаар хийсэн гүйлгээнийхээ мэдээллийг сайтар тулгаж, хянаж шалгаж байх хэрэгтэй;
- Харилцагч сард нэг удаа интернэт банкаар хийгдсэн гүйлгээний баталгааг зааврын дагуу хийж байх ёстой;
- Харилцагч нь интернэт банкаар гүйлгээ хийх үедээ гүйлгээний мэдээллийг үнэн зөв оруулж, нягтлан шалгасны үндсэн дээр гүйлгээ хийх ёстой;
- Харилцагч нь өөрийн мэдээлэлд өөрчлөлт орсон, харилцагч солигдсон тухай бүр Банкинд мэдэгдэн өөрчлөлтийг хийлгэх ёстой ба банкинд мэдэгдээгүйгээс үүдэн аливаа хариуцлагыг банк хариуцахгүй гэдгийг анхаарна уу;
- Харилцагч нь нэвтрэх нэр, нууц үг, нууцлалын төхөөрөмж, электрон кодоо бусдад алдахгүй байх, ямар нэг шалтгаанаар бусдад алдсан бол нэн даруй Банкинд мэдэгдэх хэрэгтэй ба мэдэгдээгүйгээс үүдэн аливаа хариуцлагыг банк хариуцахгүй гэдгийг анхаарна уу;
- Харилцагч нь интернэт банкны үйлчилгээгээр төлбөр тооцоог гүйцэтгэхээс өмнө Банкны “Ерөнхий нөхцөл”, төлбөр тооцоог гүйцэтгэх цагийн зохицуулалттай сайтар танилцах, тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд төлбөр тооцоог гүйцэтгэх ёстойг анхаарна уу;
- Харилцагч нь интернэт банкаар төлбөр тооцоогоо гүйцэтгэх үед харилцагчид мэдээлэх аливаа санамж, зааврыг нэг бүрчлэн биелүүлэх ёстой;
- Байгууллага нь интернэт банкны харилцагч ажилтнууддаа хяналт тавих, хяналтын зохистой тогтолцоо бий болгох үүрэгтэй гэдгийг анхаарна уу.

Гүйлгээний цаг, гүйлгээний лимиттэй холбоотой анхаарах зүйл

- Харилцагч Та интернэт банкны үйлчилгээний эрхийн лимитийн хэмжээнд гүйлгээ хийх эрхтэй гэдгийг анхаарна уу. Хэрэв танай байгууллага үүнээс өндөр эрх, нэг удаагийн гүйлгээний эрх болон гүйлгээг дан болон дараалласан хяналтаар хийхийг хүсэж буй бол интернэт банк нээлгэсэн салбартаа хандах хэрэгтэй.
- Интернэт банкны гүйлгээ нь Монгол банкнаас баталсан Банк хоорондын их дүнтэй гүйлгээг дамжуулах “Банк сүлжээ” системийн ажиллах цагийн хуваарийн дагуу хийгддэг бөгөөд “Интернэт банкны үйлчилгээний нөхцөл”-д тодорхойлсон цагийн хуваарийн дагуу хийгдэнэ.
- Банк технологийн системийн шинэчлэл, засвар үйлчилгээ хийх зорилгоор системийг түр зогсоох үед интернэт банкны вэб хуудсанд анхааруулга гаргана.

Санамжтай танилцаж, ойлгосон: _____ Баталгаат гарын үсэг /1-р гарын үсэг/

_____ Баталгаат гарын үсэг /2-р гарын үсэг/